МЭДЭЭ · 2020 оны 2-р сарын 5

“ШИНЭ ЗУУНЫ ИРГЭДИЙН СЭТГЭЛГЭЭ, ХАНДЛАГА” СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Улсын Ерөнхий Прокурорын газраас 2020 онд дэвшүүлсэн “Прокурор, ажилтны ажлын арга барил, хандлагыг өөрчлөх, санал, санаачлагыг дэмжих, хүний нөөцийг чадавхижуулах...” зорилтын хүрээнд Хөвсгөл аймгийн прокурорын газар нийт прокурор, захиргаа, үйлчилгээний ажилтнуудаа хамруулан 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр сургалт зохион байгууллаа.

“Royal” Олон Улсын Их сургуулийн төрийн удирдлагын хөтөлбөрийн удирдагч багш Б.Байгальмаа “Шинэ зууны иргэдийн сэтгэлгээ, хандлага”, “Манлайлагч ба leadership”, “Хувийн ялалт, амжилтыг яаж бий болгох вэ? IQ+EQ+LQ=100%”, “Хувь хүний төлөвлөлт” зэрэг сэдвээр нийт 4 цагийн сургалтыг хийсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3010